“СОР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр № 2026/01 Улаанбаатар хот

“СОР” ХК–ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 10 цаг 30 минутанд “СОР” ХК-ийн хурлын танхимд эхлэв. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдиийн бүртгэл 2026 оны 04 дүгээр сарын 27-ний өдрийн 12:05 цаг хүртэл явагдаж дуусав.

Хурлыг ТУЗ-ийн гишүүн И.Дариймаа даргалав.

Тооллогын комисс-д Д.Сүхээ, Н.Баярмаа нар тус тус ажиллав.

Хурлын ирц:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 712692 ширхэг хувьцаа эзэмшигч 12 хувьцаа эзэмшигчид биеэр оролцож байгаа нь нийт саналын эрх бүхий энгийн хувьцаа болох 891 388 ширхэг хувьцааны 79,5 % болж байгаа тул Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх заалтын дагуу “ирцийг хүчин төгөлдөрт тооцох” талаарх Тооллогын комиссын шийдвэрийг Комиссын дарга Д.Сүхээ хурал даргалагчид танилцуулав.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигч	хувьцааны тоо
1	"БЛЮ СКАЙ КАШЕМИР"ХХК	420671
2	Титан инвест ХХК /Т.Цацрал /	151000
3	”Монгол даатгал”ХХК/Т.Цацрал/	78445
4	С.Мягмарсүрэн	20969
5	С.Пүрэвжав	41541
6	Ж.Энхтунгалаг	52
7	М.Шигшээ	2

8	Х.Эрдэнэсанаа	1
9	М.Нарангоо	1
10	М.Түшиг	1
11	П.Цогзолмаа	10
12	С.Дашдорж	1
	нийт	712692
	ирцийн хувь	79.95%

Хурлын дарга И.Дариймаа хурлын ирц, тооллогын комиссын тогтоолыг танилцуулан ээлжит хурлыг нээж, хурлын дэг, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулсныг Хувьцаа эзэмшигчид батлав

Хэлэлцэх асуудал:

1. **Хэлэлцэх асуудал-1:** 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх

Мэдээлэл өгөх: Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах ;

2. **Хэлэлцэх асуудал-2:** Компанийн ТУЗ-ийн гишүүдийг батлах;

3. **Хэлэлцэх асуудал-3:** ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсөв батлах;

<u>Хэлэлцэх асуудал-1:</u>

“СОР” ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Гүйцэтгэх захирал Д.Жанрай танилцуулав.

Асуулт, хариулт, санал хүсэлт :

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн

“СОР”ХК-ийн үл хөдлөх хөрөнгө болон газар шүүхийн барьцаанд байгаа гэх нотлох баримтын талаар танилцуулаад тодорхой тайлбар хүсэв.

Д.Жанрай: Одоогоор хөрөнгө хураах асуудлаар аливаа төрийн байгууллага шаардлага, албан бичиг ирүүлээгүй байгаа ба хувьцаа эзэмшигч та бүхэнд хөрөнгөө алдах эрсдэл байхгүй гэж ойлгож болно.

С.Мягмарсүрэн: Бидний өмч хураагдахгүй гэдэг ойлголт өглөө гэж ойлголоо. Хөрөнгийн барьцаа, зээлийн гэрээ нь их хэмжээний хэлцэл болохын хувьд ТУЗ, байхгүй бол ХЭ-ийн зөвшөөрөл шийдвэр гарах ёстой, тийм баримтыг бид байвал авмаар байна , байхгүй бол цаашид анхаарах хэрэгтэй.

Тэрээр цаашид Компанийн барилга дээр юу хийхээр төлөвлөж байгаа вэ? Гэх асуултанд

Санхүү эрхэлсэн захирал Н.Уганбаяр одоогоор цаашид ийм үйл ажиллагаа явуулна гэх мэдээлэл чиглэл бид дээд удирдлагаас аваагүй байна.

Д.Жанрай: Цаашид юу хийх , юуг өөрчлөх яах саналыг та бүхэн хувьцаа эзэмшигчид саналаа оруулах хэрэгтэй. ХЭ-аас санал гарвал саналыг цаашид уламжлан шийдвэр гарвал Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

С.Пүрэвжав: 2025 оны санхүүгийн тайланд эздийн өмч хасах яваад байна, энэ талаар тайлбар мэдээлэл өгнө үү?

Д.Жанрай: Манай компанийн хувьд түрээсийн орлогоо аваад татварын өрөө төлөөд явж байгаа. Улс орон даяар татварын асуудал хүнд байна.

С.Пүрэвжав: 2025 онд өрийн хэмжээ 300 аад саяар нэмэгдсэн байна.Тайлбар мэдээлэл өгнө үү?

И.Дариймаа: Эздийн өмч хасах байна гээд байна, энэ нь тодорхой үйл ажиллагаа хийгдээгүй, ашигтай ажиллаагүй гэж ойлгоно,мөн “ Блю скай”ХХК буюу нөлөө бүхий хувьцаа эзэмшигч этгээд өөрийн хөрөнгөөр “СОР”ХК-ийн байрыг бүрэн засаж янзалсан.

С.Пүрэвжав: “СОР”ХК-ийн -ын байранд дахин үнэлгээ яагаад хийхгүй байна гэх асуудлыг удаа дараа тавьж байна.

“Сор”ХК өнөөдрийн байдлаар сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл байгуулсан уу гэж асуусан С.Пүрэвжавын асуултанд Компанийн зүгээс 2025 онд ийм гэрээ хэлцэл байгуулаагүй гэж хариулсан.

Мөн түүнчлэн тэрээр “Блю скай кашемир”ХХК-ийн үйлдвэр үйлчилгээний засварын зардал болох 7,0 тэрбум төгрөгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа хурлын тэмдэглэлд тусгуулсан.

Д.Жанрай: Үнэлгээ өсөхөөр үл хөдлөх хөрөнгийн татвар нэмэгдэхээр компанид хүнд байх тул, нэн тэргүүнд татварын өрөө төлсний дараа хөрөнгийн үнэлгээний асуудлыг хийлгэх төлөвтэй байна.

С.Мягмарсүрэн: Дахин үнэлгээ хийлгэхгүй байгаа нь хөрөнгийн өнөөгийн үнэлгээ тодорхойгүй, хувьцаа эзэмшигчид бидэнд ашиггүй байна гэж үзэж байна.

“Дабль Ти консалтинг” 2022 онд хийсэн гэрээтэй танилцах шаардлагатай байна, архивт байх ёстой.

Д.Жанрай: Би ажил хүлээж авахдаа эдгээр баримтуудыг хүлээж аваагүй.

С.Мягмаржав: 2023 онд ХЭХ дээр би их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл байгуулсан уу, гэж асуухад хийгээгүй гэж И.Дариймаа хариулсан байдаг. Одоо 2 дахиа асууж байгаа тул протоколд тэмдэглүүлэх саналтай байна.

Хэдийгээр мэдээлэл авах гэж албан ёсоор хандсан ч хоёр ч удаа хариу авч чадахгүй байна.Иймд 1/Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, “СОР”ХК, “Дабль Ти консалтинг”ХХК-тай холбоотой хоорондын хийсэн гэрээний хуулбарыг авах хэрэгтэй байна. 2/“СОР”ХК-иас шүүхийн шийдвэрээс өр төлбөргүй гэх бичиг гаргуулж бидэнд өгнө үү.

1-р асуудлаар дахин санал хүсэлт гараагүй болно.

Хурал даргалагч 1-р асуудлаар Тогтоолын төсөл танилцуулж санал хураалт явуулсан ба Тооллогын комисс дүнг дараах байдлаар танилцуулав:

<u>Санал хурааалтын дүн:</u>

Зөвшөөрсөн: 10 хувьцаа эзэмшигч , 650182 ш хувьцаа /83,3%

Татгалзсан: 1/20969 ш хувьцаа/

Түдгэлзсэн:1/41541 ш хувьцаа/

Санал хурааалтын дүн: 83,3%

ШИЙДВЭР:

СОР" ХК-ийн 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг "хангалттай" гэж батлах.

Мэдээлэл өгөх : Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай;

Компанийн ТУЗ нь 2025 онд "Ногдол ашиг хуваарилахгүй талаар" шийдвэр гаргасныг Хурал даргалагч И.Дариймаа уншиж танилцуулав.

Хэлэлцэх асуудал-2: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг улираан томилох;

Хурал даргалагч И.Дариймаа ТУЗ-д 9 хүнийг нэр дэвшүүлэхээр шийдвэрлэснийг тэдгээр гишүүдийн танилцуулгын хамт танилцуулав.

ТУЗ-д нэр дэвшүүлсэн гишүүдэд куммулятив аргаар санал хураасан дүнг Тооллогын комиссын дарга Д.Сүхээ танилцуулав.

Санал хурааалтын куммулятив аргаар тооцсон дүн:

№	Хувьцаа эзэмшигчид	Эзэмшиж буй хувьцааны тоо	Д.Нямхүү	С.Б.Громов	Д.Жанрай	Л.Таня	Н.Ханбулаг	И.Дариймаа	А.Санчирмаа	Ж.Эрдэнэтуяа	Д.дашгомбо
1	"БЛЮ СКАЙ"ХХК	420671	420671	420671	420671	420671	420671	420671	420671	420671	420671
2	Титан инвест ХХК	151000	151000	151000	151000	151000	151000	151000	151000	151000	151000
3	"Монгол даатгал"ХХК	78445	78445	78445	78445	78445	78445	78445	78445	78445	78445
4	С.Мягмарсүрэн	20969			188712						
5	С.Пүрэвжав	41541			373869						
6	Ж.Энхтунгалаг	50	50	50	50	50	50	50	50	50	50
7	М.Шигшээ	2	2	2	2	2	2	2	2	2	2
8	Х.Эрдэнэсанаа	1	1	1	1	1	1	1	1	1	1
9	М.Нарангоо	1	1	1	1	1	1	1	1	1	1
10	М.Түшиг	1	1	1	1	1	1	1	1	1	1
11	П.Цогзолмаа	10	10	10	10	10	10	10	10	10	10
12	С.Дашдорж	1	1	1	1	1	1	1	1	1	1
	нийт	712692	229511	229511	792092	229511	229511	229511	229511	229511	229511

ШИЙДВЭР:

1. "СОР" ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр дараах нэр бүхий хүмүүсийг томилох:

ЕРДИЙН гишүүнээр:

1.Д.Нямхүү

2.С.Б.Громов

3.Д.Жанрай

4.Л.Таня

5.Н.Ханбулаг

6. И.Дариймаа

ХАРААТ БУС гишүүнээр

1. А.Санчирмаа

2. Ж.Эрдэнэтуяа

3.Д.Дашгомбо

Хэлэлцэх асуудал- 3:

ТУЗ-ийн 2026 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай;

ТУЗ-ийн 2026 оны төсвийн талаар **И Дариймаа** дараах тайлбар мэдээлэл хийв.

“Сор”ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг идэвх санаачилга, үр дүнтэй ажиллуулах хүрээнд тодорхой урамшуулал олгож байхаар шийдсэн ба түүнчлэн үйл ажиллагаанд шаардагдах тодорхой төсвийг тооцож нийтдээ **8 350 000 ,0 /найман сая гурван тавин мянган/** төгрөгөнд багтаасан болохыг танилцуулав.

Хурал даргалагч 3-р асуудлаар Тогтоолын төсөл танилцуулж санал хураалт явуулсан ба Тооллогын комисс дүнг дараах байдлаар танилцуулав:

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 12 хувьцаа эзэмшигч , 712692 ш хувьцаа /100%/

Санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн: 12 хувьцаа эзэмшигч , 712692 ш хувьцаа /100%/

Татгалзсан: 0

Түдгэлзсэн: 0

Санал хураалтын дүн: 100%

Хурал даргалагч И.Дариймаа Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дэгийн дагуу асуудлуудыг хэлэлцээд өндөрлөснийг мэдэгдэв.

Хурал 2026 оны 4 р сарын 27 -ны өдрийн 12.15 цагт дуусав..

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Н.Баярмаа

Хурал даргалагч: И.Дариймаа

№	Хувьцаа эзэмшигч	хувьцааны тоо	Гарын үсэг
1	"БЛЮ СКАЙ"ХХК	420671	
2	Титан инвест ХХК/О.Хулан/	151000	
3	”Монгол даатгал”ХХК/О.Хулан/	78445	
4	С.Мягмарсүрэн	20969	
5	С.Пүрэвжав	41541	
6	Ж.Энхтунгалаг	50	
7	М.Шигшээ	2	
8	Х.Эрдэнэсанаа	1	
9	М.Нарангоо	1	
10	М.Түшиг	1	
11	П.Цогзолмаа	10	
12	С.Дашдорж	1	
	нийт	712692	
	ирцийн хувь	79.95%	